

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2022 оны 10-р сарын 24-ны өдөр

Дугаар 18/22

Орхон аймаг

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын Орхон аймаг Баян Өндөр сум Баянбулаг багийн нутаг дэвсгэрт баригдсан төвөгшлийн зэргийн Дунд ангиллын “ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА 150 ОР /ОРХОН АЙМАГ, БАЯН-ӨНДР СУМ,БАЯНБУЛАГ БАГ/” цэцэрлэгийн зориулалттай барилга байгууламжид Орхон аймгийн Засаг даргын 2021 оны 11 сарын 09-ны өдрийн А/580 дугаар шийдвэрийг үндэслэн ГХБХБГ-ын даргын батлан байгуулагдсан 14 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2022 оны 09 сарын 07-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1. Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний огноо: 2021-12-06, дугаар: 16/21
- 2.2. Барилга байгууламжийн зураг төслийн шифр: НТ15/2014
- 2.3. Захиалагч: /Хуулийн этгээдийн хувьд/: “Боловсрол шинжлэх ухааны яам” оноосон нэр, РД:9116621, 9011089059, Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Засгийн газрын III байр, холбоо барих утас: 70120940, 11-320358, letter@moh.gov.mn цахим хаяг;
- 2.4. Барилгын ажлыг гүйцэтгэгч: “ХЯЛГАНАТ НУГА”ХХК оноосон нэр, РД:5460956 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: 9011278067, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар: БУ12-1854/17, Хаяг: Улаанбаатар /нийслэл/, Баянгол дүүрэг/, 6-р хороо 10-р хороолол, 47/1-15 тоот, холбоо барих утас: 94850103, цахим хаяг: h.nuga_llc@yahoo.com
- 2.5. Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч байгууллага: оноосон нэр, РД:.....Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар,, барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг:/нийслэл/, /дүүрэг/

- /хороо/ /хороолол/ /хашаа, хаалга/-ныдугаар,холбоо барих утас, цахим хаяг;
- 2.6.
- 2.7. Барилга байгууламжийн зураг төслийн байгууллага: **“Ноёдын туурь”ХХК** оноосон нэр, РД:**4253256, 1911009147** Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, **ЗТЗ7-508/19** зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: **Дархан-уул аймаг /аймаг/, Дархан сум /сум/ 14-р баг, 2-р гудамж 45-р байр 59 тоот хаалга /хаалга/-ны дугаар, холбоо барих утас: 88093031, цахим хаяг: noyodiintuurillc@gmail.com;**
- 2.8. Барилга байгууламжийн ашиглагч байгууллага: **“Орхон аймгийн 27-р цэцэрлэг”** оноосон нэр, РД:**4409337** Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: **2070001114**, Хаяг: **Орхон аймаг /нийслэл/, Баян-Өндөр сум, Баянбулаг баг /хороо/ 1-р гудамж /хороолол/ 27-р цэцэрлэг /хашаа,/-ныдугаар, холбоо барих утас: 94355004, цахим хаяг: tsetseg.5004@gmail.com;**
- 2.9. Барилга байгууламжийн төлөв байдал: **Шинэ барилга**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул
- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1. Энэхүү **“ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА 150 ОР /ОРХОН АЙМАГ, БАЯН-ӨНДР СУМ,БАЯНБУЛАГ БАГ”** барилга угсралтын ажил, түүнтэй холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос **ДҮГНЭСЭН** нь:

3.2. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.2. Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.3. Комиссын акт хуудас, хуралдааны тэмдэглэлхуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1. Ангиллын бага хүчин чадал бүхий **“ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА 150 ОР /ОРХОН АЙМАГ, БАЯН-ӨНДР СУМ,БАЯНБУЛАГ БАГ** барилгын ажлыг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

**“ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА 150 ОР /ОРХОН АЙМАГ,
БАЯН-ӨНДР СУМ, БАЯНБУЛАГ БАГ”**

Комиссын дарга:

Орхон аймгийн газрын харилцаа, барилга,
хот байгуулалтын газрын БХБХ-ийн дарга

/Г.Буянхүү/

Нарийн бичгийн дарга:

“Хялганат нуга” ХХК-н гүйцэтгэх захирал

/Д.Ганбаатар/

БАТЛАВ

ГХБХБГ-ЫН
ДАРГА

Д.ЦОЛМОН

ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМ, БАЯНБУЛАГ БАГ
“ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА, 150 ОР”-ЫГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дугаар 18/2022

2022-09-07

№	Чиг үүрэг	Овог нэр албан тушаал	Гарын үсэг
1	Комиссын дарга:	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар Г.Буянхүү / ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга /	
2	Нарийн бичгийн дарга:	Г.Золбоо / БХТ-ийн хяналтын инженер /	
	Гишүүд:	Мэргэжлийн хяналтын газрын төлөөлөл	
3		Д.Жаргал / Эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын ахлах байцаагч, хэлтсийн дарга /	
4		А.Сайнсанаа /Барилга техник хяналтын улсын байцаагч/	
		Онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагын төлөөлөл	
5		Л.Бат-Ирээдүй /Гал түймрийн улсын хяналтын байцаагч/	
		Архивын байгууллагын төлөөлөл	
6		Л.Түмэннаст /Архивын тасгийн дарга/	
		Аймгийн засаг Засаг даргын тамгын газрын төлөөлөл	
7		Р.Галбаатар /ЗДТГ-ын ХБТХОХ-ийн мэргэжилтэн/	
		Захиалагч байгууллагын төлөөлөл	
8		Л.Цэцэгээ /ГХБХБГ-ын Барилгын ахлах мэргэжилтэн/	
		Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл	
9		Ц.Мөнх-Эрдэнэ / МБХЭЭХ-ны Орхон аймаг дахь салбарын тэргүүн /	
		Хангагч байгууллагын төлөөлөл	
10		Д.Содномжамц / “Эрдэнэт-Ус ДТС” ОНӨХК-ний ерөнхий инженер/	
11		Б.Эрдэнэцогт / “ЭБЦТС” ТӨХК-ийн Ерөнхий инженер /	
12		Ц.Зориг /МХС-ТӨХК-ийн Орхон салбарын ерөнхий инженер/	
	Ашиглалт өмчлөл хариуцсан байгууллагын төлөөлөл		
13	Б.Баттөр /ОНӨГ-ын мэргэжилтэн/		
14	О.Ариунгэрэлт / Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга/		
15	Г.Батцэцэг /27 дугаар цэцэрлэгийн эрхлэгч/		
	Зураг төслийн байгууллагын төлөөлөл		
16	Д.Энхдалай /“Ноёдын туурь” ХХК-ийн захирал /		
	Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл		
17	Д.Ганбаатар /“Хялганат нуга” ХХК-ийн төслийн менежер /		

Ирц:

ГХБХБГ-ын ахлах мэргэжилтэн

/Л.Цэцэгээ/

ОРХОН АЙМГИЙН БАЯНБУЛАГ БАГИЙН 150 ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГЫГ
АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВАХ УЛСЫН КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 09 сарын 07

Эрдэнэт

Баянбулаг багийн 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг ашиглалтад хүлээн авах улсын комиссын бүрэлдэхүүн 2022 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн 09:00 цагт, 82,3 хувийн ирцтэй хуралдав.

Улсын комиссын бүрэлдэхүүнд:

Комиссын дарга: ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга Г.Буянхүү

Комиссын нарийн бичгийн дарга: БХТ-ийн хяналтын инженер Г.Золбоо

Гишүүд:

Мэргэжлийн хяналтын газрын төлөөлөл:

Д.Жаргал-Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч, хэлтсийн дарга

Н.Азхүү-Барилга техникийн хяналтын улсын байцаагч

Онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагын төлөөлөгч:

Э.Сонинзаяа-Гал түймрийн улсын хяналтын байцаагч

Захиалагч байгууллагын төлөөлөл:

Л.Цэцэгээ-ГХБХБГ-ын барилгын ахлах мэргэжилтэн

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл:

Ц.Мөнх-Эрдэнэ-МБХЭЭХ-ны Орхон аймаг дахь салбарын тэргүүн

Хангагч байгууллагын төлөөлөл:

О.Энх-Ариун-Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК-ны ИЭЗБТХ-ийн дарга

Н.Давааням-ЭБЦТС ТӨХК-ийн ашиглалтын инженер

Ц.Зориг-МХС-ТӨХК-ийн Орхон салбарын ерөнхий инженер

Ашиглалт өмчлөл хариуцсан байгууллагын төлөөлөл:

Б.Баттөр-ОНӨГ-ын мэргэжилтэн

О.Ариунгэрэлт-Боловсрол шинжлэх ухааны газрын дарга

Л.Тайвантуул-Боловсрол шинжлэх ухааны газрын СӨБ хариуцсан мэргэжилтэн

Г.Батцэцэг-27 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Д.Ганбаатар-Хялганат нуга ХХК-ны төслийн менежер

СОНССОН НЬ:

Г.Буянхүү: Хялганат нуга ХХК нь ХААГ-2014/ХҮИ.1.1.185, ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА-150 ОР гэрээний дугаартай 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Гишүүдийн санал дүгнэлтийг хэлэлцье.

ХЭЛЭЛЦСЭН НЬ :

Н.Азхүү: 2020 оны улсын комиссын акт нэгэнт зурагдаагүй учраас Засгийн газрын тогтоол, Барилгын тухай хуульд заасны дагуу дахин ажиллуулж байна. Үүний ач холбогдол нь чанарт ач холбогдолтой. Барилгын тухай хуулийн 16 дугаар зүйл, 16.3-т зааснаар

барилга байгууламжийг улсын комисс ажиллаад гарын үсэг зурж хүлээж авсанаас хойш нэг жилийн хугацаанд зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гарсан эвдрэл гэмтлийг компани бүрэн хариуцаж засаж өгнө. 2023 оны 09 сар хүртэл, дээр нь 2023 оны улсын комисс зурагдсанаас хойш нэг жилийн дараа ашиглагч, захиалагч, гүйцэтгэгч энэ гурван байгууллага субъект сууж байгаад энэ байгууллага дээр гарсан алдаа зөрчлийг бүгдийг нэмээд протокол хөтлөөд эднийх засвараа хийгээд боллоо гээд гурван тал гарын үсэг зурсанаар зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болсонд тооцно гэж хуулинд заасан. Хэрэв протокол хөтлөөгүй бол зүгшрүүлэх, тохируулах хугацаа цааш үргэлжлээд байх юм. Протоколд гарын үсэг зурж зүгшрүүлэх, тохируулах хугацааг дууссанаас хойш дахиад 3 жил, өөрөөр хэлбэл баталгаат хугацаа болно. Хуулийн хугацаагаар 4 жил, энэ компани хэр урагштай хийхээс шалтгаалан энэ хугацаанд гарсан эвдрэл гэмтэлийг засах ёстой. Зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болсоноор дараагийн санхүүжилт орно.

Д.Жаргал: Инженерийн шугам сүлжээ, агааржуулалтын системд холбогдох мэргэжлийн байгууллагаар акт зуруулж аваагүй, гал тогооны агааржуулалтын системийг шалгаад тусдаа акт үйлдээд гарын үсэг зуруулж баталгаажуулна. Анги бүлгүүдийн халаах хэрэгсэлд хаалт байх ёстой стандартаараа ингэж заасан, зурагт байхгүй байна уу яагаад байхгүй байна гэдгийг шалгах, үүнийг хийх шаардлагатай байна. Ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ангид шаардлагатай. Дотоод орчны агаарын шинжилгээг улсын хэмжээнд бүх байгууллагаас шаардаж байгаа. Тэр тусмаа хүүхдийн байгууллага учраас шаардана. Дотоод орчны агаарын шинжилгээг "Ногоон титэм" компанитай холбогдож хийлгэ. Гадаад орчны тохижилт зам талбай, тоглоомын талбайг зурагт заасны дагуу стандартад ямар байх ёстой юм яг түүний дагуу бүрэн чанартай тохижуулж хийгээд зургаар баталгаажуулж хүлээлгэж өгнө. Инженерийн шугам сүлжээ, дотор засалд хэрэглэсэн материалуудын чанарын сертификатыг хавсаргана. Дутуу ажлуудаа гүйцээж хийнэ. Үүрэг даалгаврын биелэлт, бусад мэргэжлийн байгууллагуудын өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр эрүүл ахуйн хувьд эцсийн байдлаар ашиглалтад хүлээж авах саналтай байна.

О. Ариунгэрэлт : Гадаа талбайн тохижилтыг зураг, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ. Мэдээж хэрэг зураг стандарт дээр гадна сүүдрэвч өргөстэйгөөрөө будаггүй байна гэж байхгүй байх. Тийм учраас гадаа сүүдрэвчний хэсэг хүүхдийн бие рүү өргөс орох магадлалтай тул будах, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ. Гадаа ногоон зүлэг, эко хавтан зэргийг стандартын дагуу гүйцээх. Мөн цэцэрлэгийн 2 хаалган дээр цахилгаанаар ажилладаг халуун хөшиг байх ёстой тэр байхгүй байна тэрнийг хий. Галын дохиолол ашиглалтын явцад аянга цахилгаантай холбоотой ажиллахгүй байгаа гэсэн зүйл байна. Энэ бол хамгийн түрүүнд хийгдэх зүйл. Үүнийг хийх үүрэг даалгавар өгч байна. Мөн мэргэжлийн байгууллагын өгсөн үүрэг даалгаврыг хийж гүйцэтгэснээр үүрэг даалгавар биелэлтийг хангагдлаа гэж үзэж хүлээж авна.

Ц.Зориг: Гадна холбоожуулалтын ажил хийгдсэн байна. Гадна холбоожуулалтын агаарын баганыг тойрох цэгийг аймгийн газрын алба, кадастрын зургаар баталгаажуулалтыг хийлгэх хэрэгтэй байна гэж үзэж байна. Дотор монтаж, кабель, холбоо дохиоллыг зургийн

дагуу бүрэн татаж хийж хаягжуулах шаардлагатай. Галын дохиоллын төхөөрөмж ажиллахгүй байгааг хэвийн ажиллагааг хангаж, онцгой байдлын ажилтант шалгуулах шаардлагатай. Эдгээр ажлыг гүйцээж хийсэн тохиолдолд үүрэг даалгавар биелсэнд тооцох боломжтой.

Ц.Мөнх-Эрдэнэ: Тусгай хэрэгцээт хүүхдийн ариун цэврийн өрөөнд 4ш бариул хийж өгмөөр байна. Өмнө өгсөн гадна хашлага хийх үүрэг даалгаварыг хийсэн байна. Бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах саналтай байна.

ГХБХБГ- барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Л.Цэцэгээ СӨБ-ын мэргэжилтэн саналаа хэлээрэй.

Л. Тайвантуул: Манай дарга ерөнхийд нь хэлчихлээ. Нэмээд гадаа налуу хавтанг суулгаж өгөх, борооны усанд доошоо суусан байгааг арматур төмрөөр тогтоосон байна. Үүнийг сайн лав суулгах, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, барилгын доод хаяавч хэсгийн плитануудыг гүйцээж наах зэрэг саналтай байна.

Н.Давааням: 04, 022 щитүүдэд газардуулгын эсэргүүцлийг хэмжүүлэх, зарчмын схемийг сэргээж тодорхой болгох, щитүүд дээр аюулгүй ажиллагааны плакатыг наах, кабельд бирк зүүх мөн цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцлийг тодорхой болгох шаардлагатай байна. Эдгээр ажил болон бусад гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах саналтай байна.

Г.Батцэцэг: Миний хэлэх санал мэргэжлийн хүмүүсийн заавар зөвлөмж, үүрэг даалгавартай давхцаж байна. Галын дохиоллын системийг засах ажиллуулах, орох гарах 2 хаалганы халуун хөшгийг хийх, гадна тоглоомын талбайд тоглоом нэмэлтээр байрлуулах юмуу эсвэл тоглоомыг томруулах саналтай байна. Эдгээр ажлуудыг хийлгэж, үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах саналтай байна.

Б.Баттөр: Зурган дээр цэцгийн мандал өндөр байсан байна. Тэрнийгээ хий. Гүйцэтгэлийн бичиг баримтан дээр гэрээний төсөв, гүйцэтгэлийн төсвийг хавсаргах, гаднах нийтийн эзэмшлийн талбайг зураг төсвийн дагуу хийж гүйцэтгэх, гүйцэтгэлийн баримтын нэг хувийг хүлээлгэн өгөх, комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авах саналтай байна.

О.Энх-Ариун: 2022 онд манай ерөнхий инженерийн өгсөн үүрэг даалгавар биелэлт дээр актууд дээр манайхаас гарын үсэг байхгүй. Энэ 2021 оны 11 сард биелсэн гээд гарын үсэг зурсан байна. Нэг бүрчлэн шалгахад яг хэвээрээ байна. Энэ ямар учиртай юм болоо эсвэл өөр үүрэг даалгавар өгсөн юм болов уу? Үүнийг асуумаар байна.

Д.Ганбаатар: Инженерийнх нь гарын үсэг мөн байна уу?

О.Энх-Ариун: Мөн байна.

Д. Ганбаатар: Тухайн үед өгсөн үүрэг даалгавар нь биелсэн болоод гарын үсэг зурсан байгаа.

О.Энх-Ариун: Биелэсэн нь хаана байна. Энд дандаа хуучин гарын үсэг байна. Шалгасан биш бичсэн актууд байна. Шугам сүлжээний холбоо дохиолол гэдэг чинь хамгийн чухал асуудал шүү дээ. Хүүхдийн амь насанд ч хүрэх эрсдэлтэй. Заавал гарын үсэг зуруулах шаардлагатай.

Л.Цэцэгээ : Үүнийгээ саналын хуудас дээрээ бичиж өгөөрөй.

Д.Ганбаатар: Ашиглаад 4-5 жил, цэцэрлэг ашиглалтад ороод 3 жил болж байна.

Д.Буянхүү: Баталгаажуулсан акт гэдэг бол чухал. Баримт бичиг баримт шүү дээ. Архивт орно.

О. Ариунгэрэлт : Өөрийн хариуцсан ажилдаа хариуцлагатай хандмаар байна. Өнөөдөр гэхэд саналын хуудас тарааж өгөхөд өөрийн салбарын анхан шатны бичиг баримтын шинэчлэл зэргийг мэдэхгүй байна. Бичиг баримтын гүйцэтгэлд ингэж хариуцлагагүй хандаж болохгүй. Ийм сайхан барилга барьж өгчихөөд, энэ бичиг баримтын гүйцэтгэл юман дээрээ хариуцлагагүй хандаж болохгүй. Цаашдаа чолон барилга барих байлгүй, байгууллага төлөөлж яваа хүний хувьд ч хариуцлагатай хандмаар санагдаж байна.

Д.Ганбаатар: Олон жил болсон учраас зарим зүйлүүд нь үнэхээр олдохгүй асуудал байна.

Н.Азхүү: Өмнө өгсөн шаардлагуудаа хэрэгжүүлсэн юм байна. Ганц нэг үлдсэн юм ч байна. Хүүхдийн тоглоомын талбайг тохижуулсан байна. О.Ариунгэрэлт даргын хэлдгээр чинь нэг жаахан сэтгэл гаргаад хүмүүсээ ажил хийж байхад нь өөрөө ирж хянаад явчихсан бол танайх овоо юмаа хийсэн байна. Уул нь хүрэлцэхүйц хэмжээний эко хавтан авж өгсөнийг хамаагүй энд тэнд тавиад дутаасан юм байна гэж харлаа. Одоо ажлаа хийлгүүлэхдээ хяналттай хийлгүүлээчээ. Барилга барьж гүйцээцээд гаднах тохижилтын ажил дээр удаад байна. Одоо тэгэхээр хөрөнгө гаргаад комиссоос өгсөн үүрэг даалгаврыг дулаан дээр хийгээд ашиглагч байгууллагадаа фото зургаар баримтжуулаад эргээд гарын үсэг зуруулаарай. Нэгдүгээрт ил далд ажлын актыг захилагчаар баталгаажуулаагүй байна. Дутуу зүйл байна гүйцээ. Хоёрдугаарт барилгын 00 түвшин зургийн дагуу тавигдсан эсэхийг нотлох акт олдохгүй байна. Гуравдугаарт аяган суурийг улыг нь хүртэл ухаад эргэж булахдаа шороог нь 90% буюу 1.6 гр.см.куб болтол нягтруулсан эсэх чинь актаар тогтоогдохгүй байна. Үүнийг надад үзүүлээч ээ. Дөрөвдүгээрт ногоон байгууламж, мод зүлгийг зургийн дагуу хийгээгүй байна. Энийг ашиглагчтайгаа тохироод ирэх жил манай Эрдэнэт 1 тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд 10 сая мод тарина гээд хүн бүр оролцож байгаа. Цэцэрлэгтэйгээ тохироод улиас, хайлаас модыг нь авч өгөөд хамтарч ажиллах хэрэгтэй байна. Тоглоомын талбайн будаагүй орхисон модон хийцүүдийг будах, гүйцээх, элсийг солих, налууд тавьсан эко хавтанг гүйцээх, барилгын эргэн тойронд ховхорсон плитаг наах зэрэг 7 зүйл байна. Эдгээрийг хийж гүйцэтгэвэл ашиглалтад авахад татгалзах зүйлгүй.

Г.Буянхүү: Өмнө бас комисс ажиллаж байсан. Манай дарга бас 2 асуудлыг надад хэлсэн. Нэг нь ангиудын аваарын хаалганы аюулгүй байдлыг хангах хэрэгтэй. Нөгөө нь тоглоомын талбайн цамхагт тоглоомыг томсгох шаардлагатай. Манай хот байгуулалтын мэдээллийн санд гүйцэтгэлийн зураг, барилга, инженерийн шугам сүлжээний техник

хүчин чадлыг загвар хүснэгтийн дагуу танилцуулж цахим санд өгөх ёстой. Нормчиллын сангийн хураамжийг барилгын хөгжлийн төвийн дансанд тушаах хэрэгтэй. Барилгад хувийн хэрэг нээж ашиглагчид өгөх шаардлагатай. Ийм даалгаврыг үүрэг болгож байна. Ер нь бол 2014 оноос хойш маш удаан баригдсан. Тэр үед ажиллаж байсан Галбаатар инженертэй би ирж байсан тэгэхэд компанийн ажилчид хоолгүй байна гээл уурлаад сууж байсан. Ийм жижиг зүйлээс хугацаа алдаж, өнөөдөр ашиглалтад авах асуудал яригдаж байна. Энэ бол цэвэр танай компанийн асуудал байгаа ажил болгон дээр том шаардлагыг комиссын гишүүд тавихгүй байна. Ерөөсөө л сэтгэл гаргаад жижиг ажлуудыг хийх асуудал байна. Харж байхад анзаарагдаж байна. Бордурь тавихад ашигласан утас татсан арматурыг аваад хаях хэрэгтэй. Хүүхэд унаж бэртэх аюултай. Хариуцлагатай байх хэрэгтэй байна. Комиссын гишүүдийн шийдвэрээр 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийн барилгыг ашиглалтад хүлээж авах шийдвэр гарч байна. Та 14 хоногийн хугацаанд комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаварыг чанартай сайн биелүүлж хангах хэрэгтэй байна. Бүрэлдэхүүнийг хангаж хурал хийсэн гишүүдээ баярлалаа.

Л.Цэцэгээ: Ирээгүй хоёр, гурван хүнээс саналын хуудсанд ашиг сонирхлын зөрчилгүй эдгээр хуудсыг бүрдүүлж аваад протоколыг дэлгэрэнгүй бичээд, хамгийн сүүлд саналын хуудас, ашиг сонирхлын хуудсыг 2 дахь эгнээнд баталгаажуулаад PDF болгоод манай байгууллага руу акт зурагдахаас өмнө ирүүлнэ. Бичиг баримтын бүрдлийг сайн хангах, 2020 онд ажилласан комиссын үүрэг даалгаварын биелэлтийг манай байгууллага хурааж авна. Хугацаандаа багтааж ажиллахыг үүрэг болгож байна.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ :

ХААГ-2014/ХҮИ.1.1.185, ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА-150 ОР гэрээний дугаартай 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг улсын комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад авахаар шийдвэрлэв.

Хурал 11³⁰- минутад дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ХЯЛГАНАТ НУГА ХХК-НЫ ТӨСЛИЙН МЕНЕЖЕР  Д.ГАНБААТАР

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН:

Улсын комиссын бүрэлдэхүүнд:

Комиссын дарга: ГХБХБГ-ын БХБХ-ийн дарга

Г.БУЯНХҮҮ

Комиссын нарийн бичгийн дарга:

БХТ-ийн хяналтын инженер

Г.ЗОЛБОО

Гишүүд:

Мэргэжлийн хяналтын газрын төлөөлөл:

Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын
улсын байцаагч, хэлтсийн дарга

Д.ЖАРГАЛ

Барилга техникийн хяналтын улсын байцаагч

Н.АЗХҮҮ

Онцгой байдлын асуудал хариуцсан байгууллагын төлөөлөгч:

Гал түймрийн улсын хяналтын байцаагч

Э.СОНИНЗАЯА

Захиалагч байгууллагын төлөөлөл:

ГХБХБГ-ын барилгын ахлах мэргэжилтэн

Л.ЦЭЦЭГЭЭ

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх ашгийг хамгаалах байгууллагын төлөөлөл:

МБХЭЭХ-ны Орхон аймаг дахь салбарын тэргүүн

Ц.МӨНХ-ЭРДЭНЭ

Хангагч байгууллагын төлөөлөл:

Эрдэнэт-Ус ДТС ОНӨХК-ны ИЭЗБТХ-ийн дарга

О.ЭНХ-АРИУН

ЭБЦТС ТӨХК-ийн ашиглалтын инженер

Н.ДАВААНЯМ

МХС-ТӨХК-ийн Орхон салбарын ерөнхий инженер

Ц.ЗОРИГ

Ашиглалт өмчлөл хариуцсан байгууллагын төлөөлөл:

ОНӨГ-ын мэргэжилтэн

Б.БАТТӨР

Боловсрол шинжлэх ухааны газрын дарга

О.АРИУНГЭРЭЛТ

27 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

Г.БАТЦЭЦЭГ